



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 08 өдөр

Дугаар 1161

Шивээговь сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3, Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 92 дугаар “Газар зохион байгуулалт хийх журам батлах тухай” тогтоолын 3.11 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.“Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө”-г боловсруулах ажлын хүрээнд газрын доройтлыг бууруулах, биологийн олон янз байдлыг хамгаалах асуудлыг тусгахад шаардлагатай мэдээллээр ханган ажиллах, боловсруулсан төлөвлөгөөний төслийн хэрэгжилтэд хяналт тавих ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

(Засаг даргын орлогч)

Гишүүд:

(1 дүгээр багийн Засаг дарга)

(2 дугаар багийн Засаг дарга)

(Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)

(Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн)

(Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:

(Газрын даамал)

2.“Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө”-ний төслийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлж, холбогдох саналыг тусган төлөвлөгөөний төслийн эцсийн хувилбарыг сумын Засаг даргад танилцуулахыг ажлын хэсгийн ахлагчид үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.СУГАРМАА